



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО



# ИНФЛЯЦ, ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ

ТАНИЛЦУУЛГА

2017

Инфляц, үнийн өөрчлөлтийн талаар танилцуулгатай холбоотой мэдээлэл ба санал хүсэлт байвал доорх хаяг болон веб сайтад хандана уу.

---

**Хаяг:** Засгийн газрын III байр,  
Бага тойруу -44, Улаанбаатар -11  
Монгол улс

**Вэб хаяг:** [www.nso.mn](http://www.nso.mn), [www.1212.mn](http://www.1212.mn)

**Утас:** 1900-1212

### **Холбогдох мэргэжилтэн**

**Утас:** 51-261561 /Д.Батсүх, Ж.Болортуяа/

### **Зөвлөмж**

Энэхүү тайланд агуулагдсан гол мэдээллүүд Үндэсний статистикийн хорооны мэдээллийн санд байдаг бөгөөд хувь хүн, албан байгууллага ямар нэгэн тусгай зөвшөөрөлгүйгээр бүрэн ашиглаж болно.

### **Мэдээллийн эх үүсвэр**

Энэхүү тайланд ашигласан өгөгдлүүд нь хамгийн сүүлийн үеийн тоон үзүүлэлтүүдийг тусгасан. Мэдээллийн эх үүсвэр нь худалдаа, үйлчилгээний цэгүүдээс цуглуулагдсан үнийн мэдээлэл юм.

### **Танилцуулгыг боловсруулсан:**

Эдийн засгийн статистикийн газар, Үнийн албаны ахлах шинжээч Д.Батсүх, шинжээч Ж.Болортуяа

---

## **АГУУЛГА**

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	<b>3</b>
ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ	<b>4</b>
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	<b>5</b>
ОРШИЛ	<b>6</b>
ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ	<b>7</b>
БҮЛЭГ 1. ЖИН БА САГСЫГ ШИНЭЧИЛСЭН ТУХАЙ ТОЙМ	<b>9</b>
БҮЛЭГ 2. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС	<b>13</b>
2.1. ИНФЛЯЦ	<b>13</b>
2.2. ЗАРИМ ГОЛ НЭРИЙН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ	<b>18</b>
БҮЛЭГ 3. ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ИНФЛЯЦ	<b>24</b>
ТАНЫ МЭДЛЭГТ-ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКСИЙГ ХЭРХЭН АШИГЛАЖ БОЛОХ ВЭ?	<b>28</b>
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	<b>32</b>

---

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АНУ	Америкийн нэгдсэн улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ОПЕК	Газрын Тос Экспортлогч Орнуудын Байгууллага
ӨНЭЗС	Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа
ХЗХБҮА	Хувийн зориулалттай хэрэглээний бараа, үйлчилгээний ангилал
ХҮИ	Хэрэглээний үнийн индекс
ХҮУИ	Хэрэглээний үнийн улсын индекс
УБ	Улаанбаатар
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага

---

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Өрхийн хэрэглээний жин, түүний өөрчлөлт, улсын түвшинд, 2010 болон 2015 оноор.....	10
Хүснэгт 2. Инфляцын түвшин, 2014-2017 оноор, хэрэглээний бараа, үйлчилгээний бүлгээр .....	13
Хүснэгт 3. Инфляцын жилийн дундаж түвшин, 2014-2017 .....	14
Хүснэгт 4. Бүсийн инфляцын жилийн түвшин, 2014-2017, хувь .....	15
Хүснэгт 5. Хэрэглээний үнийн индекс, өмнөх оныхтой харьцуулснаар, аймаг, нийслэлээр, 2014-2017, хувь .....	16
Хүснэгт 6. Хэрэглээний үнийн индекс, хүнсний бараа, ундаа, усны бүлгийн дэд бүлгээр, өмнөх оныхтой харьцуулснаар, 2014-2017, хувь .....	18
Хүснэгт 7. Хураасан төмс, хүнсний ногоо, улсаар, жилээр, тонноор .....	20
Хүснэгт 8. 1997 оны төгрөгийн одоогийн үнэлгээ .....	30
Хүснэгт 9. Зарим бараа, үйлчилгээний жилийн дундаж үнэ, 1997 болон 2017 оноор, төгрөг.....	31

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Хэрэглээний бараа, үйлчилгээний сагс, түүний өөрчлөлт, 2010 болон 2015 оноор .....	11
Зураг 2. Инфляцын түвшин, сараар, өмнөх оны жилийн эцсийнхтэй харьцуулснаар.....	14
Зураг 3. Хэрэглээний үнийн индекс, өмнөх оныхтой харьцуулснаар, аймаг, нийслэлээр, 2017 он, хувь .....	17
Зураг 4. Мах, махан бүтээгдэхүүний үнийн улсын индекс (өмнөх оны 12 сар =100).....	19
Зураг 5. Хонины махны үнэ, ястай, кг, 2014-2017 он, сараар .....	19
Зураг 6. Төмс, хүнсний ногооны үнийн улсын индекс (өмнөх оны 12 сар =100) .....	20
Зураг 7. Төмсний үнэ, кг, 2014-2017 он, сараар .....	21
Зураг 8. Талх, гурил, будааны бүлгийн үнийн улсын индекс (өмнөх оны 12 сар =100) .....	21
Зураг 9. Гурилын үнэ, жилийн дунджаар, 2014-2017, төрлөөр .....	22
Зураг 10. Шатахууны үнэ, 2014-2017 оны сараар, төрлөөр .....	23
Зураг 11. Инфляцын жилийн түвшин, аналитикийн бүлгээр, хувиар, 2017 он.....	24
Зураг 12. Инфляцын жилийн түвшин, бүсээр, хувиар, 2017 он .....	25
Зураг 13. Дэлхийн зах зээлийн барааны үнийн гол өөрчлөлт .....	25
Зураг 14. Улс орнуудын жилийн инфляцын түвшин, 2017 он .....	26

---

## ОРШИЛ

2017 онд Монгол Улсын инфляцын түвшин хэд байсан, ямар төрлийн бараа, үйлчилгээний үнэ гол өөрчлөлтийг бий болгов, зарим гол нэр төрлийн барааны үнэ, түүний өсөлт, бууралт, мөн түүнчлэн глобал инфляцыг товчхон, ойлгомжтой байдлаар харуулах нь уг танилцуулгын зорилго юм.

Инфляцыг хэмжих хэд хэдэн арга байдгийн нэг нь хэрэглээний үнийн индекс юм. Инфляцын түвшинг тодорхойлох, төрөөс санхүү, мөнгө зээлийн бодлогыг хэрэгжүүлэх, хүн амын цалин, тэтгэвэр, тэтгэмж бусад орлогын хэмжээг индексжүүлэх тооцооны гол үзүүлэлт нь хэрэглээний үнийн индекс болдог. Түүнчлэн ХҮИ-ийг макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн нэг болох дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн аргын тооцоонд болон эцсийн ашиглалтын тооцооны өрхийн аж ахуйн эцсийн хэрэглээний зардлыг зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхэд ашиглана.

Үндэсний Статистикийн Хороо нь өөрийн чиг үүргийн хүрээнд өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн мэдээллийг сар бүр цуглуулж, хэрэглээний үнийн индексийг тооцон олон нийтийн хүртээл болгож байна.

Үндэсний Статистикийн Хороо 1991 оноос Олон Улсын Валютын Сангийн аргачлалаар ХҮИ-ийг тооцож эхэлсэн ба түүнээс хойш суурь, сагс, жинг 1995, 2000, 2005, 2010, 2015 онуудад шинэчилсэн. 1991-2006 он хүртэл Улаанбаатар хотын ХҮИ-ээр хэрэглээний үнийн улсын индексийг төлөөлүүлэн тооцдог байсан. 1997 оноос аймгуудын индексийг тусад нь тооцож, зарлаж ирсэн.

Манай улсын нутаг дэвсгэр, газар зүйн байршлаас хамаарч, бараа, үйлчилгээний үнэ, тариф аймгуудад харилцан адилгүй, улсын хэмжээний нийт өрхийн талаас илүү хувь нь аймаг, орон нутагт амьдардаг зэргээс шалтгаалан ХҮИ-ийн тооцоонд аймгийн ХҮИ-ийг оруулах шаардлагатай болсон. 2006 оны 1 дүгээр сараас эхлэн ХҮИ-ийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, олон улсын аргачлалын дагуу улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.

2017 оны 4 дүгээр сараас эхлэн ХҮИ-ийг 2015 суурьт шилжүүлэн хувийн зориулалттай хэрэглээний бараа, үйлчилгээний ангиллын /ХЗХБҮА/ үндсэн 12 бүлгийн дагуу 373 (Улаанбаатар хотод 344, аймгуудад 238 нэр төрөл) нэр төрлийн бараа, үйлчилгээгээр ХҮИ-ийг тооцож байна.

## ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Инфляц – Бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн ерөнхий түвшин өсөж, тэр хэмжээгээр мөнгөний ханш буурах үзэгдлийг инфляц гэнэ. Инфляц нь нэг талаас хэрэглээний сагсан дахь бараа, үйлчилгээний үнэ, өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний эрэлт, мөн тэдгээрийн нийлүүлэлт, хангамжийн харьцаа, нийт хэрэглээний зардалд эзлэх хувийн жинтэй холбогдон өөрчлөгдөх боловч нөгөө талаас мөнгөний нийлүүлэлт, валютын ханш, хүн амын орлогын өсөлт болон бусад хүчин зүйлүүдээс хамааран өөрчлөгддөг.

Хэрэглээний үнийн индекс - Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар өөрчлөгдөж буйг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд нэг өрхөөр бус нийт өрхөөр тооцогдсон үнийн дундаж өөрчлөлтийг харуулна.

Өрх болгон өөрийн зарлагын бүтэцтэй, түүнчлэн бараа, үйлчилгээний үнүүд нь ялгаатай хэмжээгээр өөрчлөгддөг учраас үнийн өсөлт өрх бүрт ижилхэн нөлөөлдөггүй. Хэрэв тухайн өрхийн мөнгөн зарлагын дийлэнх хувийг эзэлдэг бараа, үйлчилгээний үнэ өсвөл инфляцын нөлөөллийг ихээр мэдэрнэ. Харин үнэ нь харьцангуй тогтвортой бараа, үйлчилгээнд нийт зардлынхаа дийлэнх хэсгийг зарцуулсан бол тэр өрхөд үнийн өсөлтийн нөлөөлөл бага мэдрэгдэнэ.

Хэрэглээний сагс - Дундаж орлоготой өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалт юм. 2017 оны байдлаар Улсын хэрэглээний сагс нийт 12 бүлгийн 373 бараа, үйлчилгээнээс, Улаанбаатар хотын сагс 344, аймгийн сагс 238 бараа, үйлчилгээнээс бүрдэж байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин - Өрхийн худалдаж авсан бараа, үйлчлүүлсэн үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь юм. Бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлт нь хэрэглэгчийн зарцуулсан зардлын дүнд хэрхэн нөлөөлөхийг илэрхийлнэ.

Хүн амын тархалт, нас хүйсийн бүтэц, өрхийн орлогын түвшин, бараа, үйлчилгээний чанар зэрэг хүчин зүйлийн өөрчлөлтөөс өрхийн хэрэглээний бүтэц байнга өөрчлөгдөж байдаг. Үүнтэй уялдуулан хэрэглээний сагсны нэр төрөл болон бараа, үйлчилгээний жинг шинэчлэх шаардлагатай байдаг тул ҮСХ нь суурь үе, сагс, жинг 5 жил тутамд шинэчлэдэг.



---

| Суурь үе /суурь он/ - Индексийн утгыг нэгж буюу 100-тай тэнцүү гэж сонгож авсан үеийг хэлнэ.

Хэрэглээний үнийн индексийг өмнөх сарынхтай, өмнөх оны эцсийнхтэй, өмнөх оны мөн үеийнхтэй, суурь үетэй харьцуулсан байдлаар хугацааны хувьд 4 түвшинд тооцдог.

| Суурь инфляц<sup>1</sup> гэдэг нь хэрэглээний барааны сагснаас үнийн хэлбэлзэл ихтэй зарим барааг хасч үнийн түвшинг тооцсоныг хэлнэ. Ихэвчлэн хүнс болон түлш шатахууны үнийн савалгаанаас шалтгаалан зарим тохиолдолд төгрөгийн худалдан авах чадвар ХҮИ-т бодит тусгалаа олж чаддаггүй тул үнийн хэлбэлзэл ихтэй эдгээр бүлгүүдийг хасан суурь инфляцыг тооцдог.

| Дефляц - Инфляцын эсрэг үзэгдэл бөгөөд үнийн ерөнхий түвшин буурах үйл явц юм. Энэ үзэгдэл нь бараа, үйлчилгээг худалдан авах хүмүүсийн эрэлт, хэрэгцээ буурснаар үйлдвэрлэгч компаниудыг өөрсдийн бүтээгдэхүүнийг хямд үнээр борлуулж алдагдал хүлээхэд хүргэдэг.

| Өргөн хэрэглээний бараа, үйлчилгээ - Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа (ӨНЭЗС)-ны үр дүнд 0.2 болон түүнээс дээш хувийн жин эзэлж буй бараа, үйлчилгээг ойлгоно.

---

| <sup>1</sup> Төв банкнаас улирлын хэлбэлзэл ихтэй мах, сүү болон хүнсний ногооны дэд бүлгүүдийн ХҮИ-ийн сагснаас хасч инфляцыг дахин тооцож эдийн засаг дахь үнийн ерөнхий түвшин хаашаа хөдөлж байгааг тодорхойлдог.

## **БҮЛЭГ 1. ЖИН БА САГСЫГ ШИНЭЧИЛСЭН ТУХАЙ ТОЙМ**

### ***Хэрэглээний үнийн индексийн жин ба сагсыг шинэчлэх шаардлага***

ХҮИ-ийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангаж байх үүднээс хэрэглээний сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчлэн тооцож байхыг олон улсын байгууллагаас зөвлөмж болгосон байдаг.

Нийгэм, эдийн засагт гарсан өөрчлөлтөөс үүдэн өрхийн хэрэглээний бүтцэд өөрчлөлт орох, бараа, үйлчилгээ зах зээлд худалдаалагдахаа болих эсвэл шинээр гарч ирэх, хэрэглэгчийн орлогын өөрчлөлтөөс шалтгаалан хэрэглээний бүтэц өөрчлөгдөх зэргээс шалтгаалан хэрэглээний үнийн суурь, сагс, жинг шинэчлэх шаардлага бий болдог.

Мөн түүнчлэн үндэсний тооцооны тооцооллын суурь үеийг 5 жил тутам шинэчилж, ХҮИ-ийг дефлятор болгон ашигладаг.

Иймд, хэрэглээний үнийн индексийн сагс, жинг бүхэлд нь 5 жилд 1 удаа, чанар, нэр төрөл нь хурдан өөрчлөгддөг бараа, үйлчилгээг тухай бүр шинэчлэх шаардлагатай болсон. Ийнхүү, хэрэглээний үнийн индекс тооцох сагс, жинг 2015 оны ӨНЭЗС-ны үр дүнгээр шинэчлэн, 2017 оны 4 дүгээр сараас эхлэн мөрдүүлж байна.

### ***Хэрэглээний сагсны жинд орсон өөрчлөлт***

ХҮИ-ийн гол зорилго нь инфляцын түвшинг тодорхойлох учир бараа, үйлчилгээний жинг тооцохдоо зөвхөн цэвэр мөнгөн зарлагыг тооцож авсан.

2015 оны ӨНЭЗС-ын үр дүнгээр тооцсон жинг 2010 оны жинтэй харьцуулан үзэхэд сүүлийн 5 жилд өрхийн хэрэглээний бүтцэд багагүй өөрчлөлт гарчээ. Хүнсний бараа, ундаа, усны бүлгийн жин 3.2 пункт, орон сууц, ус, цахилгаан түлшнийх 3.0 пунктээр буурсан бол, тээврийн бүлгийн жин 2.2 пункт, согтууруулах ундаа, тамхиных болон бусад бараа үйлчилгээнийх тус бүр 1.3 пунктээр өсжээ. Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн жин өөрчлөлтгүй, холбооны хэрэгсэл, шуудангийн

үйлчилгээнийх 0.1 пунктээр буурсан бол, бусад бүлгийнх 0.1-0.4 пунктээр өссөн байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Өрхийн хэрэглээний жин, түүний өөрчлөлт, улсын түвшинд, 2010 болон 2015 оноор

Бүлэг	2010 он	2015 он	Өөрчлөлт
<b>Нийт жин</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>-</b>
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	26.1	-3.2
Согтууруулах ундаа, тамхи	3.2	4.4	1.3
Хувцас, бөс бараа, гутал	16.1	16.6	0.4
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	9.3	-3.0
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	4.9	0.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	3.6	0.0
Тээвэр	12.2	14.4	2.2
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	4.4	-0.1
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	3.1	0.3
Боловсролын үйлчилгээ	4.7	4.8	0.1
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	3.0	0.4
Бусад бараа, үйлчилгээ	4.1	5.4	1.3

### ***Хэрэглээний сагсанд орсон өөрчлөлт***

2010 оны ӨНЭЗС-ны судалгаанд үндэслэн хэрэглээний бараа, үйлчилгээний сагс 2012-2016 онд 329 нэр төрлийн бараа, үйлчилгээнээс бүрдэж байсан бол 2015 оны ӨНЭЗС-ны судалгаанд үндэслэн хэрэглээний бараа, үйлчилгээний сагс 2017 оны байдлаар 373 нэр төрлийн бараа, үйлчилгээнээс бүрдэж байна.

Зураг 1. Хэрэглээний бараа, үйлчилгээний сагс, түүний өөрчлөлт, 2010 болон 2015 оноор



Хэрэглээний сагсанд тавигдах гол шаардлага нь тухайн сонгогдсон бараа, үйлчилгээ нь өрхийн хэрэглээний ижил төрлийн бараа, үйлчилгээг төлөөлөх чадвартай байх юм. Дараах зарчмыг баримтлан бараа, үйлчилгээг сонгосон. Үүнд:

- | Өрхийн хэрэглээний нийт зардлын 0.2 хувь ба түүнээс дээш хувь эзэлдэг бараа, үйлчилгээг сонгох,
- | Сагсанд орсон бараа, үйлчилгээний үнийг тогтмол судалж, ХҮИ-ийн тооцоонд ашиглах боломжтой байх,
- | Хүн амын хэрэглээг илэрхийлэхэд зайлшгүй орох шаардлагатай гэж үзсэн зарим бараа, үйлчилгээг нэмж оруулах.

Хэрэглээний сагсанд ороогүй бараа, үйлчилгээний зардлыг дараах аргуудаар хуваарилан тусгаж өгсөн. Үүнд:

- | Шууд орлуулга - сагсанд орсон ижил төстэй ойролцоо бараа, үйлчилгээний зардал дээр нэмэх
- | Шууд бус орлуулга - дэд бүлэг, бүлгийн бараа, үйлчилгээнүүдийн зардлуудад пропорционалаар хуваарилах
- | Сагсны нийт нэр төрлүүдийн зардлуудад пропорционалаар хуваарилах аргуудыг хэрэглэсэн болно.

---

Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд сонгогдсон бараа, үйлчилгээний нэр, төрлийг сонгоход:

- | Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2015 оны үр дүн,
- | Гадаад худалдааны 2015 оны жилийн эцсийн мэдээ,
- | Аж үйлдвэр, тээвэр болон холбооны салбарын 2015 оны жилийн эцсийн мэдээ,
- | Нийслэл, дүүрэг, аймгийн статистикийн газар, хэлтсийн хэрэглээний үнийн мэдээ хариуцсан мэргэжилтнүүдийн санал,
- | ОУӨЗХ-2011, 2015 онуудын өрхийн хэрэглээний сагсны нэр, төрөл,
- | Орон сууцны конторын мэдээлэл зэргийг ашигласан.

## БҮЛЭГ 2. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

### 2.1. ИНФЛЯЦ

Хэрэглээний үнийн улсын индекс өмнөх оныхоос 2014 оны эцэст 11.0 хувь, 2015 онд 1.9 хувь, 2016 онд 1.3 хувиар өссөн бол 2017 онд 6.4 хувиар өсөж, өсөлтийн хурдац 2016 оныхоос 5.1 пунктээр өссөн байна.

Хүснэгт 2. Инфляцын түвшин, 2014-2017 оноор, хэрэглээний бараа, үйлчилгээний бүлгээр хувь

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин /2010/	2014	2015	Жин /2015/	2016 <sup>2</sup>	2017	2014-2017 оны инфляц
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	8.4	-6.1	26.1	1.7	7.3	2.8
Согтууруулах ундаа, тамхи	3.2	10.3	1.4	4.4	0.8	3.7	7.3
Хувцас, бөс бараа, гутал	16.1	14.3	5.5	16.6	2.3	4.2	11.6
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	16.3	3.2	9.3	1.7	7.4	11.3
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	11.5	5.1	4.9	1.7	5.5	11.5
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	9.1	4.1	3.6	2.7	9.3	20.6
Тээвэр	12.2	8.6	1.4	14.4	-1.7	10.4	8.2
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	0.0	-0.8	4.4	-1.1	-0.5	-1.6
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	8.1	2.4	3.1	-0.1	3.9	4.9
Боловсролын үйлчилгээ	4.7	16.8	23.1	4.8	4.4	5.5	33.1
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	8.6	4.4	3.0	0.8	3.0	11.0
Бусад бараа, үйлчилгээ	4.1	11.8	5.1	5.4	2.2	7.9	18.8
<b>Ерөнхий индекс</b>	<b>100.0</b>	<b>11.0</b>	<b>1.9</b>	<b>100.0</b>	<b>1.3</b>	<b>6.4</b>	<b>9.8</b>


Инфляц 2017 оны жилийн эцэст 2014 оныхоос 9.8 хувиар өссөн байна. Үүний 2.12 нэгж (21.6 хувь) нь хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнийн өсөлтөөс, 1.91 нэгж (19.5 хувь) нь боловсролын үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөөс, 1.41 нэгж (14.4 хувь) нь орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнийн өсөлтөөс, 0.87 нэгж (8.9

<sup>2</sup> 2015=100 суурьтай тооцоогоор

хувь) нь тээврийн бүлгийн үнийн өсөлтөөс, 0.82 нэгж (8.3 хувь) нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2017 оны 12 дугаар сард өмнөх оны эцсээс 6.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 7.3 хувь (төмс, хүнсний ногооны дэд бүлгийн үнэ 21.6 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 9.6 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний дэд бүлгийн үнэ 11.6 хувь), тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 10.4 хувь (тээврийн хэрэгслийн худалдан авалтын дэд бүлгийн үнэ 23.3 хувь), орон сууц, ус цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 7.4 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 10.3 хувь), боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 5.5 хувь (бүрэн дунд боловсролын үйлчилгээний дэд бүлгийн үнэ 32.1 хувь), хувцас, бөс бараа, гутлын бүлгийнх 4.2 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг 2. Инфляцын түвшин, сараар, өмнөх оны жилийн эцсийнхтэй харьцуулснаар



Инфляцын жилийн дундаж түвшин 2017 онд 4.3 хувь болж, 2016 оныхоос 3.2 пунктээр буурчээ.

Хүснэгт 3. Инфляцын жилийн дундаж түвшин, 2014-2017, хувь

Он	2014	2015	2016	2017
Инфляцын жилийн дундаж түвшин	12.8	6.6	0.7	4.3

Харин өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, 2017 оны 1 сард инфляц 2.1 хувь гарсан нь 2017 оны хувьд хамгийн их бага өсөлт гарсан сар байсан бол 2017 оны 10 сард инфляц 6.9 хувь байсан нь хамгийн их өсөлттэй сар байлаа.

Бүсийн инфляц - Үндэсний Статистикийн Хороо нь Бүсийн инфляцыг 2012 оноос эхлэн 4 бүсээр тооцон нийтэд тархааж байна.

Хүснэгт 4. Бүсийн инфляцын жилийн түвшин, 2014-2017, хувь

<b>Бүс</b>	<b>2014</b>	<b>2015</b>	<b>2016</b>	<b>2017</b>
Баруун бүс	12.6	1.2	1.2	6.3
Хангайн бүс	12.7	4.3	1.6	4.7
Төвийн бүс	9.7	2.0	2.3	5.9
Зүүн бүс	11.2	3.4	2.1	5.1
Улсын	11.1	1.9	1.3	6.4

Бүсийн инфляцын түвшин 2014 онд бусад онуудтай харьцуулахад хамгийн өндөр байжээ.

Бүсийн инфляцын түвшинг улсын түвшинтэй харьцуулахад, 2014 онд улсын инфляцаас Баруун, Зүүн болон Хангайн бүсийн инфляц 0.2-1.7 пунктээр өндөр, Төвийн бүсийн инфляц 1.3 пунктээр доогуур байна. Баруун бүсийн инфляц 2015 онд улсын инфляцаас 0.7 пунктээр доогуур, харин бусад бүсийн инфляц 0.1-2.4 пунктээр өндөр байжээ. 2016 онд бүсүүдийн инфляцын түвшин улсын инфляцаас 0.1-1.0 пунктээр өндөр байв. Харин 2017 онд бүсүүдийн инфляцын түвшин улсын инфляцаас 0.1-1.7 пунктээр бага байв.




Хүснэгт 5. Хэрэглээний үнийн индекс, өмнөх оныхтой харьцуулснаар, аймаг, нийслэлээр, 2014-2017, хувь

Аймаг, нийслэл	2014	2015	2016	2017
<b>Ерөнхий индекс</b>	<b>111.0</b>	<b>101.9</b>	<b>101.3</b>	<b>106.4</b>
Баян-Өлгий	111.2	96.2	101.6	105.9
Говь-Алтай	109.5	102.3	102.5	103.7
Завхан	110.0	104.1	99.8	104.1
Увс	115.2	103.2	100.8	109.0
Ховд	113.7	99.2	100.8	107.9
Архангай	117.1	111.9	102.9	105.9
Баянхонгор	112.3	106.4	101.3	109.6
Булган	110.4	101.7	101.4	102.4
Орхон	112.7	100.6	101.2	105.6
Өвөрхангай	112.9	107.0	100.1	102.2
Хөвсгөл	111.8	102.3	102.6	103.0
Говь-Сүмбэр	108.4	105.9	103.5	105.3
Дархан-уул	108.5	100.0	101.9	104.9
Дорноговь	110.3	97.7	102.4	102.7
Дундговь	111.2	104.0	107.1	105.0
Өмнөговь	109.9	101.4	101.0	106.2
Сэлэнгэ	110.6	102.4	101.7	109.1
Төв	109.4	106.1	101.9	106.1
Дорнод	110.7	105.4	102.5	105.0
Сүхбаатар	111.3	104.4	101.4	105.9
Хэнтий	111.9	100.2	102.3	104.7
<b>Улаанбаатар</b>	<b>110.7</b>	<b>101.1</b>	<b>100.8</b>	<b>107.2</b>

Аймгуудад хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2017 оны жилийн эцэст өмнөх оныхтой харьцуулахад аймгуудад 2.2-9.6 хувиар өссөний дотор Баянхонгор аймагт 109.6 хувь болсон нь хамгийн өндөр үзүүлэлт байв.

Харин Улаанбаатар хотод энэ үзүүлэлт 7.2 хувьтай гарлаа. Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны эцсээс 7.2 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 7.9 хувь (мах, махан бүтээгдэхүүний дэд бүлэг 3.2 хувь), тээврийн бүлгийн үнэ 10.5 хувиар (тээврийн хэрэгслийн худалдан авалтын дэд бүлгийн үнэ 24.3 хувь) өссөн нь голлон нөлөөлжээ.

Зураг 3. Хэрэглээний үнийн индекс, өмнөх оныхтой харьцуулснаар, аймаг, нийслэлээр, 2017 он, хувь



## 2.2. ГОЛ НЭРИЙН ЗАРИМ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ

Монгол Улсын өрхийн нийт хэрэглээний 26.1 хувийг эзэлдэг хүнсний барааны үнийн өөрчлөлт нь үнийн ерөнхий өөрчлөлтөнд шууд нөлөөлж байна.

Хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2015 онд 6.1 хувиар буурч байсан бол, 2014 онд 8.4 хувь, 2016 онд 1.2 хувь, 2017 онд 7.3 хувиар өсөж байсан байна.

Хүснэгт 6. Хэрэглээний үнийн индекс, хүнсний бараа, ундаа, усны бүлгийн дэд бүлгээр, өмнөх оныхтой харьцуулснаар, 2014-2017 он, хувь

Бүлэг, дэд бүлэг	2014	2015	2016	2017
<b>ХҮНСНИЙ БАРАА, УНДАА, УС</b>	<b>108.4</b>	<b>93.9</b>	<b>101.7</b>	<b>107.3</b>
<b>Хүнсний бараа</b>	108.4	93.2	100.9	107.1
Талх, гурил, будаа	117.7	106.5	101.5	104.7
Мах, махан бүтээгдэхүүн	98.7	75.4	103.0	103.5
Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг	114.1	92.1	102.0	123.2
Төрөл бүрийн өөх, тос	107.3	105.4	98.5	111.6
Жимс, жимсгэнэ	115.3	102.5	100.9	109.1
Төмс, хүнсний ногоо	112.9	104.0	85.9	105.4
Саахар, жимсний чанамал, чихэр, шоколад	109.1	102.0	108.8	121.6
Хүнсний бусад бүтээгдэхүүн	109.1	103.7	105.3	106.8
<b>Согтууруулах бус ундаа</b>	<b>108.7</b>	<b>109.0</b>	<b>112.8</b>	<b>108.8</b>


Монгол Улсын өрхийн хэрэглээнд хүнсний бараа, үүний дотор гурил, мах, махан бүтээгдэхүүн өндөр жин эзэлдэг. Үнийн өсөлтөд голлон нөлөөлдөг хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүн, бензин, шатахуун зэрэг хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг авч үзье.

### Махны үнэ

Улаанбаатар хотын өрхийн хэрэглээний нийт мөнгөн зардлын 9.5 хувийг мах махан бүтээгдэхүүн эзэлдэг. Иймд инфляцын түвшин махны үнээс ихээхэн хамаардаг. Махны үнэ нийлүүлэлттэйгээ холбоотойгоор байнга хэлбэлздэг бөгөөд хавар, зуны улиралд өсөж, намар, өвлийн улиралд буурдаг хандлага 2014-2017 онд мөн хэвээр хадгалагдав.


Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2017 оны бүх сард өмнөх оны эцсийнхтэй харьцуулахад 3.2-29.2 хувиар өссөн бөгөөд 5 сард 29.2 хувиар өссөн нь хамгийн өндөр өсөлттэй сар байлаа. 2017 оны 12 сард мах, махан бүтээгдэхүүний үнэ тухайн онд хамгийн бага өсөлттэй байжээ. Энэ нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн индекс өсөхөд голлон нөлөөлжээ.

Зураг 4. Мах, махан бүтээгдэхүүний үнийн улсын индекс (өмнөх оны 12 сар =100)



Өнгөрсөн дөрвөн жилд хонины махны 1 кг-ын үнэ хамгийн хямд буюу 2016 оны 11 дугаар сард 3946 төг байсан бол 2014 оны 5 дугаар сард хамгийн үнэтэй буюу 7800 төгрөгт хүрч байв. 2017 оны байдлаар хонины махны үнэ 5141-7235 төгрөгийн хооронд хэлбэлзлээ.

Зураг 5. Хонины махны үнэ, ястай, кг, 2014-2017 он, сараар




### Төмс, хүнсний ногооны үнэ

Сүүлийн жилүүдэд ихэвчлэн хавар, зуны улиралд хүнсний ногооны үнэ нь өсөж, намрын улирлаас ургац хураалттай холбоотойгоор үнэ нь буурдаг нь судалгаанаас харагддаг.

2017 оны хувьд 8 дугаар сард төмс, хүнсний ногооны үнэ оны эхнээс 37.7 хувиар өссөн нь хамгийн их өссөн сар байлаа. /Зураг 7/.

Зураг 6. Төмс, хүнсний ногооны үнийн улсын индекс (өмнөх оны 12 сар =100)




Улаанбаатар хотод төмсний үнэ 2017 онд өнгөрсөн оны эцсийнхээс 39.5 хувь, луувангийн үнэ 27.8 хувь, байцааны үнэ 36.7 хувь, сонгины үнэ 7.5 хувиар өссөн нь төмс, хүнсний ногооны нийлүүлэлттэй холбоотой. Манай улс 2017 онд 82.1 мянган тонн хүнсний ногоо, 121.8 мянган тонн төмс хураасан нь 2016 оныхоос хүнсний ногоо 13.1 хувиар буюу 12.3 мянган тонноор, төмс 26.3 хувиар буюу 43.5 мянган тонноор буурсан байв.

Хүснэгт 7. Хураасан төмс, хүнсний ногоо, улсаар, жилээр, тонноор

Аймаг	Төрөл	2014	2015	2016	2017
Улс	Төмс	161 488.5	163 766.9	165 329.5	121 808.5
	Хүнсний ногоо	104 791.9	72 347.6	94 447.20	82 102.0

Улаанбаатар хотын төмсний үнийн өсөлтийг өнгөрсөн 4 жилээр харахад 2017 онд хамгийн бага өсөлттэй жил байсан ба хамгийн доод үнэ нь 660 төгрөгт хүрч байсан бол 2015 онд төмсний үнэ хамгийн өндөр байсан байна. 2015 оны 7 сард төмсний үнэ хамгийн өндөр буюу 1722 төгрөгт хүрчээ.


Зураг 7. Төмсний үнэ, кг, 2014-2017 он, сараар



### Гурилын үнэ


2017 оны байдлаар талх, гурил, будааны бүлгийн үнэ 2016 оны жилийн эцсийнхээс 4.7 хувиар өсжээ.

Зураг 8. Талх, гурил, будааны бүлгийн үнийн улсын индекс (өмнөх оны 12 сар =100)



Улаанбаатар хотод гурилын үнэ 2017 оны жилийн эцэст 2016 оны жилийн эцсийнхээс савласан дээдийн дээд гурилын үнэ 3.6 хувь, савласан дээд зэргийн гурилын үнэ 2.9 хувь, савласан 1-р зэргийн гурилын үнэ 2.4 хувь, савласан 2-р зэргийн гурилын үнэ 4.8 хувиар өсжээ.

Зураг 9. Гурилын үнэ, жилийн дунджаар, 2014-2017 он, төрлөөр



\* Гурил, 1-р зэрэг, кг, "Алтан тариа" ХК, савласан гурилын үнэ нь 2015 оноос судлагдсан.

### Сургалтын төлбөр

Ихэвчлэн жил бүрийн 8 дугаар сард их, дээд сургуулиудын сургалтын төлбөр нэмэгддэг. 2017 онд судалгаанд сонгогдсон төрийн өмчит их дээд сургуулийн сургалтын төлбөр өмнөх оныхоос 0.6 хувиар, харин хувийн их, дээд сургуулийн сургалтын төлбөр 10.0 хувиар, хувийн бага болон дунд сургуулийн сургалтын төлбөр өмнөх оныхоос 8.8-32.1 хувиар нэмэгдсэн нь боловсролын бүлгийн үнийн дүнг 7.5 хувиар нэмэгдүүлсэн байна.


### Автобензин, шатахууны үнэ

Инфляцын өөрчлөлтөд бодитойгоор нөлөө үзүүлэгч нэг хүчин зүйл нь шатахууны үнийн өөрчлөлт юм. Улаанбаатар хотод АИ-80 бензины үнэ 2017 оны жилийн эцэст 2016 оны жилийн эцсийнхээс 2.1 хувь, АИ-92 бензины үнэ 6.5 хувь, дизель түлшний үнэ 4.9 хувиар өссөн байна.

2017 оны 2 дугаар сард шатахууны үнэ 2016 оны 12 дугаар сарын байдлаарх шатахууны үнээс 20-59 төгрөгөөр өссөн байна. 2017 оны 3 дугаар сард шатахууны үнэ өмнөх сарынхаас 10-41 төгрөгөөр өссөн бол үүнээс хойш он дуустал үнэ тогтвортой байжээ.

Бензин, шатахууны үнийн төлөөлөл болгож Аи-92-ын үнийн мэдээллийг авч үзье. 2014 оны 3 болон 4 дүгээр сард үнэ хамгийн өндөр буюу 1 литр тутмын үнэ 1670 төг болж, 2016 оны 7 дугаар сард 1530 төгрөгт хүрсэн нь энэ дөрвөн жилийн хамгийн хямд үнэ байлаа.

Зураг 10. Шатахууны үнэ, 2014-2017 оноор, сараар, төрлөөр





### БҮЛЭГ 3. ДЭЛХИЙН УЛС ОРНУУДЫН ИНФЛЯЦ

ОУВСангийн судалгаагаар дэлхийн инфляц 2017 онд 3.0 хувьд хүрч өссөн бөгөөд 2018 онд дэлхийн инфляц 3.5 хувьд хүрнэ гэж таамаглажээ.


2017 оны инфляцын жилийн түвшин хөгжингүй эдийн засагтай орнуудын инфляц 1.7 хувь, хөгжиж буй зах зээлтэй болон хөгжиж буй эдийн засагтай орнуудын инфляц 4.0 хувьд хүрчээ. Европын холбооны улс орнуудад 1.7%, Евро бүсийн улс орнуудад 1.5% байлаа. Мөн Азийн Хөгжлийн банкны тооцоогоор хөгжиж буй Азийн улс орнуудын инфляцын дундаж түвшин 2017 онд 2.3% байв. Саб-Сахарын Африкийн орнуудын жилийн инфляц 11.0 хувьд хүрсэн нь хамгийн өндөр үзүүлэлт байв.

Зураг 11. Инфляцын жилийн түвшин, аналитикийн бүлгээр, хувиар, 2017 он



Дэлхийн 2017 оны жилийн инфляцын түвшинг бүсээр нь авч үзвэл, Хойд африкийн бүсэд инфляц 14.4 хувь байсан нь хамгийн өндөр өсөлттэй инфляцтай бүс байв. Харин Зүүн азийн бүс нутагт инфляц 1.4 хувь байсан нь хамгийн бага инфляцтай бүс нь байлаа.

Зураг 12. Инфляцын жилийн түвшин, бүсээр, хувиар, 2017 он



Глобал инфляцыг өсөхөд өндөр үнэтэй бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт голлон нөлөөлсөн байна.

Зураг 13. Дэлхийн зах зээлийн барааны үнийн гол өөрчлөлт



Ялангуяа газрын тос, байгалийн хий, шатахууны үнийн өөрчлөлт улс орнуудын инфляцын өөрчлөлтөд голлон нөлөө үзүүлсэн байна. Нэг баррель газрын тосны үнэ 2017 оны эхний хагас жилд 56 америк доллараас 46 америк доллар болж


буурсан байна. Энэ нь 2016 онд ОПЕК (Газрын Тос Экспортлогч Орнуудын Байгууллага) болон ОПЕК-ийн бус голлох үйлдвэрлэгч орнуудын хооронд АНУ-ын газрын тосны нийлүүлэлт их байснаас шалтгаалан үйлдвэрлэлтийг бууруулах гэрээний ашигтай байдалд эргэлзээг бий болгожээ. Гэвч 2017 оны хоёрдугаар хагас жилээс нэг баррель газрын тосны үнэ сэргэж эхэлсэн байна. 2017 оны 12 сард нэг баррель газрын тосны үнэ 67 америк долларт хүрч өссөн нь глобал инфляцын өсөлтөд түлхэц үзүүлсэн.

2017 онд газрын тосны бус бүтээгдэхүүний үнэ өссөн нь металл үнийн өсөлтөөс голлон шалтгаалжээ. Зуны улиралд богино хугацаанд буурах хандлагатай байсан металын үнэ ялангуяа 3 дугаар улиралд өсөж, энэ өсөлт нь экспортлогч зарим улс орнуудад хүчтэй эрэлт, нийлүүлэлтийн тасалдалын улмаас бий болжээ.

Хүнсний барааны үнэ 2017 онд буурсан бөгөөд энэ нь шар буурцаг, улаан буудай, далдуу модны тос болон эрдэнэ шишийн их хэмжээний нийлүүлэлтээс шалтгаалсан байна. Түүнчлэн хүнсний барааны үнийн өөрчлөлтөд металын үнийн өсөлт нөлөө үзүүлжээ.

### Зарим улсын инфляцыг товчхон авч үзье.

Зураг 14. Улс орнуудын жилийн инфляцын түвшин, 2017 он



Оросын холбооны улсын инфляцын түвшин 2017 онд оны эхнээс 2.5 хувь болж өссөн байна. Хүнсний барааны үнэ өмнөх оны эцсээс 1.9 хувиар, хүнсний бус барааны үнэ 2.8 хувиар, үйлчилгээ 4.4 хувиар тус тус өссөн байна. Мөн түүнчлэн суурь индекс нь 2.1 хувь болж өсжээ.

Хятад улсын инфляцын жилийн дундаж түвшин 2017 онд 1.6 хувь болж өссөн байна. Харин өмнөх жилийн эцэстэй харьцуулахад инфляц 1.8 хувь байжээ. Бараа, үйлчилгээний үнэ хотуудад 1.9 хувиар, мужуудад 1.7 хувиар өссөн байна. Хүнсний бүлгийн барааны үнэ 0.4 хувиар буурч, хүнсний бус барааны үнэ 2.4%-иар өссөн байна. Хэрэглээний барааны үнэ 1.1 хувь, үйлчилгээний үнэ 3.0 хувиар өсжээ.

Америкийн нэгдсэн улсын инфляц 2017 онд 2.1 хувьд хүрч өсжээ. Хүнсний бүлгийн барааны үнэ өмнөх оныхтой харьцуулахад 1.6 хувиар өссөн байна. Тамхины үнэ 6.5 хувь, согтууруудах үндааны үнэ 1.4 хувиар өсжээ. Эрчим хүчний бүлгийн индекс 2017 онд 6.9 хувиар өссөн байна. Үүнд бензин, шатахууны үнэ 10.7 хувь, байгалийн хий 4.7 хувиар өссөн бол цахилгаан 0.5 хувиар буурчээ. Өмнөх оныхтой харьцуулахад, эм тарианы үнэ 2.8 хувь, эмнэлгийн үйлчилгээний үнэ 5.1 хувиар өссөн байна. Авто машины даатгалын үнэ 7.9 хувиар өссөн бол шинэ машины үнэ 0.5 хувь, хуучин машины үнэ 1.0 хувиар буурсан байна. Холбооны үйлчилгээ 4.9 хувь, агаарын тээврийн үйлчилгээ 4.0 хувиар буурчээ. Харин боловсролын үйлчилгээний үнэ 2.0 хувиар өссөн нь 1993 оноос хойш хамгийн бага өсөлт байв.

Япон улсын инфляцын жилийн дундаж түвшин 2017 онд 0.5%, шинэ хүнсийг оролцуулахгүйгээр 0.5%, шинэ хүнс болон эрчим хүчийг оролцуулахгүйгээр тооцвол 0.1% байсан байна. Энэхүү өсөлт нь голлон байгалийн хий, цахилгаан, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, согтууруулах ундааны үнийн өсөлтөөс шалтгаалжээ.

Венесуэл улс нь 2017 онд дэлхийн хамгийн өндөр инфляцтай улс байв. Энэ улсын инфляц 2014 онд 68.5 хувь, 2015 онд 270.7 хувь, 2016 онд 800 хувь байсан бол 2017 онд 3000 хувьд хүрсэн байна. 2017 онд 1 доллар нь 111 413.23 боливартай тэнцүү ханштай байсан байна. Гол нэрийн зарим барааны үнэ 13 883 365 боливар (125 америк доллар) байгаа нь цалингийн доод хэмжээг 70 нийлүүлснээс илүү байсан байна. Цалингийн доод түвшин нь 177 000 боливар буюу 1.5 америк доллартай тэнцэнэ.

## ТАНЫ МЭДЛЭГТ-ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКСИЙГ ХЭРХЭН АШИГЛАЖ БОЛОХ ВЭ?

Хэрэглээний үнийн индексийг үндсэн гурван зорилгоор ашигладаг. Үүнд:

1. Инфляцын түвшинг тодорхойлох бөгөөд энэ нь эдийн засгийн байдлыг харуулах маш чухал үзүүлэлт юм.
2. Үнийн өөрчлөлтийн үед эдийн засгийн бусад мэдээллийг засварлах, инфляцын нөлөөлөлгүй бодит төгрөгт шилжүүлэх, зэрэгцүүлэх буюу бодитоор үнэлэхэд ашиглана. Жишээлбэл, тодорхой хугацааны туршид жижиглэн худалдааны салбарын борлуулалтын орлогын өөрчлөлтийг инфляцын нөлөөлгүйгээр, бодитоор үнэлэх боломжийг олгоно. Мөн төгрөгийн худалдан авах чадварын өөрчлөлтийг хэмжинэ.
3. Төрийн санхүү, мөнгө зээлийн бодлогыг хэрэгжүүлэх, хүн амын цалин, тэтгэвэр, тэтгэмж бусад орлогын хэмжээг индексжүүлэхэд хэрэглэнэ. Жишээлбэл, цалингийн доод түвшин тогтооход ашиглана.

### Хэрэглээний үнийн индексийг ашиглан хийж болох ТООЦООЛОЛ-ууд

| Нэрлэсэн үнэ (оны үнэ)-ийг бодит үнэ (зэрэгцүүлэх үнэ)-д шилжүүлэх:

- 2017 онд худалдаалагдсан бараа, үйлчилгээний үнэ 1997 онд ямар үнэтэй байсан бэ?

Хэрэглээний үнийн индекс нь тодорхой цаг хугацаанд үнэ хэрхэн өөрчлөгдөж байгааг тооцоолоход ашиглагдана. Өнөөдөр таны халаасанд 5000 төгрөг байна гэж авч үзье. Тэгвэл энэ мөнгөөр худалдан авч болох бараа, үйлчилгээг 20 жилийн өмнө буюу 1997 онд хэдэн төгрөгөөр худалдан авах байсан бол?

- 1997 оны ХҮИ = 100.0
- 2017 оны ХҮИ = 538.8
- Дараах томъёог ашиглан 2017 оны 5000 төгрөг 1997 онд хэдэн төгрөг байсныг тооцоолж болно:

$$1997 \text{ оны үнэ} = 2017 \text{ оны үнэ} \times (1997 \text{ оны ХҮИ} / 2017 \text{ оны ХҮИ})$$

$$1997 \text{ оны үнэ} = 5000 \text{ төгрөг} \times (100.0 / 538.8)$$

## 1997 оны үнэ = 927.9 төгрөг

| Өмнөх хугацааны үнүүдийг оны үнэтэй харьцуулах:

- 1997 онд худалдаалагдсан бараа, үйлчилгээний үнэ 2017 онд ямар үнэтэй байх байсан бэ?

20 жилийн өмнө буюу 1997 онд талхны дундаж үнэ 235.8 байжээ. Талхны үнэ ихэнхи бараа, үйлчилгээнээс хурдан эсвэл удаанаар өссөн гэдгийг та хэрхэн мэдэж болох вэ? Хэрэглээний үнийн индексийг ашиглан тухайн цаг үеийн мөнгийг одоогийн төгрөгт шилжүүлнэ.

- 1997 оны ХҮИ = 100.0
- 2017 оны ХҮИ = 538.8
- 1997 онд талхны үнэ 235.8 төгрөг
- Дараах томъёог ашиглан талхны 1997 оны үнийг 2017 оны үнэд шилжүүлнэ:

$$2017 \text{ оны үнэ} = 1997 \text{ оны үнэ} \times (2017 \text{ оны ХҮИ} / 1997 \text{ оны ХҮИ})$$

$$2017 \text{ оны үнэ} = 235.8 \text{ төгрөг} \times (538.8 / 100.0)$$

$$2017 \text{ оны үнэ} = 1271 \text{ төгрөг}$$

| Инфляцын түвшинг тооцоолох:

- 2016-2017 оны хооронд хэрэглээний үнийн инфляцын түвшин хэд байсан бэ?

Үнийн өсөлтийн заалтыг хамтын гэрээ хэлэлцээр, даатгалын бодлого болон түрээсийн гэрээнд тусгах нь бий. ХҮИ нь инфляцын нөлөөнд байгаа цалин, төлбөр, олговрын түвшинг засварлахад хамгийн өргөнөөр ашиглагддаг үнийн хэмжилт юм. Хэрэв түрээсийн гэрээ 2016 онд сар бүр 500000 төгрөг төлөхөөр заасан бол, 2017 онд инфляцаас шалтгаалан түрээсийн төлбөрийг хэрхэн засварлан шинэчлэх вэ?

- 2016 оны ХҮИ<sup>3</sup> = 100.8
- 2017 оны ХҮИ<sup>4</sup> = 107.2
- Анхны түрээсийн төлбөр = 500000 төгрөг
- Дараах томъёог ашиглан 2016-2017 оны инфляцын түвшинг тооцоолно:

$$\text{Инфляцын түвшин} = (2017 \text{ оны ХҮИ} - 2016 \text{ оны ХҮИ}) / 2016 \text{ оны ХҮИ} \times 100$$

<sup>3 4</sup> Суурь онтой харьцуулснаар, суурь он 2015=100

**Инфляцын түвшин =  $((107.2-100.8) / 100.8) \times 100$**

**Инфляцын түвшин = 6.4%**

2017 онд тухайн түрээсийн төлбөр 6.4 хувиар өсөж, 532060.4 төгрөг болох боломжтой байжээ.

## Сонирхолтой статистик

Дээр харуулсан ХҮИ-ийн хэрэглээтэй холбоотойгоор зарим нэг сонирхолтой статистик тоо баримтыг авч үзье.

| 1997 оны 1, 100, 500, 1000, 5000, 10000 төгрөг 2017 оны хэдэн төгрөгтэй тэнцүү үнэлгээтэй вэ?

Хүснэгт 8. 1997 оны төгрөгийн одоогийн үнэлгээ

Он	Индекс	Төгрөг	Төгрөг	Төгрөг	Төгрөг	Төгрөг	Төгрөг	Төгрөг
1997	100.0	1.0	100.0	500.0	1000.0	5000.0	10000.0	20000.0
1998	106.0	1.1	106.0	530.0	1060.0	5299.8	10599.6	21199.2
1999	116.6	1.2	116.6	582.8	1165.6	5828.0	11655.9	23311.8
2000	126.0	1.3	126.0	630.1	1260.2	6301.0	12602.1	25204.2
2001	136.1	1.4	136.1	680.4	1360.7	6803.6	13607.2	27214.4
2002	138.4	1.4	138.4	692.1	1384.3	6921.5	13843.0	27685.9
2003	144.9	1.4	144.9	724.7	1449.3	7246.6	14493.1	28986.3
2004	160.9	1.6	160.9	804.3	1608.5	8042.5	16085.0	32170.0
2005	176.1	1.8	176.1	880.3	1760.7	8803.4	17606.9	35213.8
2006	186.9	1.9	186.9	934.6	1869.2	9345.8	18691.6	37383.3
2007	220.1	2.2	220.1	1100.6	2201.3	11006.4	22012.7	44025.4
2008	268.7	2.7	268.7	1343.7	2687.4	13436.8	26873.6	53747.1
2009	280.1	2.8	280.1	1400.7	2801.4	14007.0	28013.9	56027.8
2010	316.6	3.2	316.6	1582.8	3165.6	15827.9	31655.7	63311.4
2011	344.7	3.4	344.7	1723.7	3447.3	17236.5	34473.1	68946.2
2012	393.0	3.9	393.0	1965.0	3929.9	19649.7	39299.3	78598.6
2013	442.1	4.4	442.1	2210.6	4421.2	22105.9	44211.7	88423.4
2014	490.8	4.9	490.8	2453.8	4907.5	24537.5	49075.0	98150.0
2015	500.0	5.0	500.0	2500.2	5000.4	25001.9	50003.9	100007.7
2016	506.4	5.1	506.4	2531.8	5063.7	25318.3	50636.5	101273.0
2017	538.8	5.4	538.8	2694.2	5388.3	26905.1	53883.4	107766.7

Эндээс, та 1997 онд 1000 төгрөгөөр худалдаж авч болох бараа, үйлчилгээг 2017 онд 5388.8 төгрөгөөр, 1997 онд 5000 төгрөгөөр худалдаж авч болох бараа, үйлчилгээг 2017 онд 26905.1 төгрөгөөр худалдаж авах болжээ гэдгийг харж болно.

| 20 жилийн өмнө зарим бараа, үйлчилгээ хэдэн төгрөгийн үнэтэй байсан бэ?

Хүснэгт 9. Зарим бараа, үйлчилгээний жилийн дундаж үнэ, 1997 болон 2017 оноор, төгрөг

<b>Бараа</b>	<b>1997 он</b>	<b>2017 он</b>
Гурил, 1-р зэрэг, кг	363.2	1030.0
Талх, Атар	235.8	1171.6
Цагаан будаа, кг	387.0	2648.9
Хонины мах, кг	799.8	6239.3
Үхрийн мах, кг	828.4	7390.4
Шингэн сүү, 1л	364.2	1481.7
Тараг, 1л	417.9	2274.3
Элсэн чихэр, кг	572.2	2527.1
Шоколад, 100гр	426.7	2029.1
Алим, кг	531.7	4218.7
Төмс, кг	297.5	883.8
Байцаа, кг	362.5	1605.1
Лууван, кг	640.8	1277.7
Сонгино, кг	662.3	1368.0
Өндөг, 1 ш	123.0	299.7
Автобусны тасалбар	100.0	500.0
Хот доторхи таксины хөлс, 1км	200.0	800.0
Бензин, А-76, 1 литр	210.0	-
Киноны тасалбар, дунджаар	458.3	8000.0



## АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Хэрэглээний үнийн индекс тооцох аргачлал, ҮСХ, 2016 он
2. Хэрэглээний үнийн индексийн 2014-2017 оны саруудын бюллетень танилцуулга, хүснэгтүүд
3. Хэрэглээний үнийн улсын индекс, ХЗХБҮА-ын 3 оронгийн түвшинд хүснэгтүүд
4. Улаанбаатар хотын бараа, үйлчилгээний үнэ
5. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан - <http://www.1212.mn/>
6. Монгол банкны сайт - <http://www.mongolbank.mn/>
7. Дэлхийн банкны сайт - <http://www.worldbank.org/>
8. Дэлхийн эдийн засгийн төлөв, 2018 оны 4 сар  
<http://www.imf.org/external/datamapper/PCPIPCH@WEO/OEMDC/ADVEC/WEO/WORLD>
9. Жилийн тайлан 2017, Европын төв банк  
<https://www.ecb.europa.eu/pub/pdf/annrep/ecb.ar2017.en.pdf>
10. Азийн хөгжил тойм, Азийн хөгжлийн банк, 2018 он  
<https://www.adb.org/sites/default/files/publication/411666/ado2018.pdf>
11. Хэрэглээний үнийн индексийн сарын мэдээ, Оросын холбооны улсын статистикийн алба, 2017 оны 12 сар  
[http://www.gks.ru/bgd/free/b04\\_03/lssWWW.exe/Stg/d03/1.htm](http://www.gks.ru/bgd/free/b04_03/lssWWW.exe/Stg/d03/1.htm)
12. Хэрэглээний үнийн индексийн сарын мэдээ, Хятадын үндэсний статистикийн товчоо, 2017 оны 12 сарын бюллетень  
[http://www.stats.gov.cn/english/PressRelease/201801/t20180111\\_1572341.html](http://www.stats.gov.cn/english/PressRelease/201801/t20180111_1572341.html)
13. Хэрэглээний үнийн индексийн сарын мэдээ, АНУ-ын хөдөлмөрийн статистикийн товчоо, 2017 оны 12 сарын бюллетень  
[https://www.bls.gov/news.release/archives/cpi\\_01122018.pdf](https://www.bls.gov/news.release/archives/cpi_01122018.pdf)
14. Хэрэглээний үнийн индексийн 2017 оны жилийн танилцуулга, Японы албан ёсны статистикийн портал сайт  
<https://www.e-stat.go.jp/en/stat>

---

15. Панам Пост-өмнөд америкийн мэдээ болон анализийн сайт

<https://panampost.com/karina-martin/2018/01/02/socialist-venezuela-ends-2017-with-the-worlds-largest-inflation-rate/?cn-reloaded=1>

16. Статистикийн портал сайт - <https://www.statista.com/>